



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/722

Алтай хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн Босго үнэ шинэчлэн батлах тухай 124 дүгээр тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Газар тариалан, жимс жимсгэнэ", "108 сая мод тарьж, ургуулах" төсөл арга хэмжээний хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн 15,960,000 (арван таван сая есөн зуун жаран мянга) төгрөгийн хөрөнгөөр санхүүжигдэх "Контент бэлтгэх" ажлыг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2.Дээрх төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг тухай бүр нь шийдвэрлэн ажиллахыг Засаг даргын зөвлөх (Д.Батбилэг)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР